

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
АГЕНТЛАГ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАТАЙ
БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2024 оны 01 дүгээр сарын 05

№ 01/56

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагад шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж, иргэдэд хүргэх төрийн болон нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, харьяа байгууллагын удирдах ажилтны хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, эцсийн үр дүнг үнэлж, дүгнэхэд оршино.

1.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон нэг талаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар (цаашид "Нийслэлийн Засаг дарга" гэх), нөгөө талаас Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн парк ОНӨТҮГ-ын дарга С.Батжаргал нар (цаашид "Удирдах ажилтан", хамтад нь "Талууд" гэх) 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

1.3. Талууд Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, бусад хууль тогтоомж болон Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох" тухай 62 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн "2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгавар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны "Нийслэлийн 2024 оны төсөв батлах тухай" 122 дугаар тогтоол, энэхүү гэрээний хугацаанд баталсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллана.

1.4."Тухайн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас тухайн жилд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, төсөв, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, хугацаа, хариуцах нэгжийг тусгав.

Хоёр.Удирдах ажилтны хүлээх үүрэг.

2.1.Удирдах ажилтан энэхүү гэрээгээр дараах үүрэг хүлээнэ:

2.1.1.нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;

2.1.2.Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг цомхон, тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах болон төрийн албанд чадахуйн зарчим /мерит/-ыг тууштай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйг сайжруулах;

2.1.3.байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;

2.1.4.хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээх ба Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд төлөөлж, гарсан үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;

2.1.5.төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх;

2.1.6.хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс НЗДТГ, Бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран өөрийн байгууллагын хариуцах индексийн үзүүлэлтийг тогтох, индексийн суурь түвшинг нягтлах, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан хийж гүйцэтгэх;

2.1.7.хотын хөгжлийн индексийн өөрийн байгууллагын хамаарах үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, хүрсэн үр дүнг 2024 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох;

2.1.8.хотын хөгжлийн индекс болон тухайн байгууллагын суурь мэдээллийг орон зайд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн санд тухай бүр оруулах;

2.1.9.чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормыг иргэн аж ахуй нэгж байгууллагуудад сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх;

2.1.10.төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлэх;

2.1.11.чиг үүргийн хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг өөрийн цахим хуудас болон төрийн үндэсний судалгааны нэгдсэн системд тухай бүр нийтэлж, дүн шинжилгээ хийх;

2.1.12. аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах;

2.1.13. нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг тайлагнах;

2.1.14. энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;

2.1.15. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, өөрийн цахим хуудас болон олон нийтэд мэдээлэх;

2.1.16. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бсраа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;

2.1.17. хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангахтай холбоотой Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаал, өгсөн чиг үүргийн биелэлтийг хангах, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн өмнө хариуцах;

2.1.18. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллах;

2.1.19. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, түүнтэй хамт баталсан бусад хуулиар олгосон эрхийн хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

2.1.20. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх

Гурав Нийслэлийн Засаг даргын хүлээх үүрэг

3.1. Нийслэлийн Засаг дарга энэхүү гэрээгээр дараах үүрэг хүлээнэ:

3.1.1. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний бүх шатны агентлаг, харьяа байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хариуцлагыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээг авах;

3.1.2.нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.3.Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд сахилга, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

3.1.4.харьяа байгууллагуудад төсвийн зардлыг хэмнэх, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, удирдлага, зохион байгуулалтаар хангах;

3.1.5.худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн, нутгийн захиргааны байгууллагуудад тогтмол зөвлөмж, чиглэл өгч, сургалт, мэдээллээр хангах;

3.1.6.төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий харьяа байгууллагын удирдлагатай байгуулсан гэрээг дүгнэхэд тухайн удирдах ажилтны иргэдэд цахимаар үзүүлсэн үйлчилгээний тоо, чанар, хүртээмжийг харгалзах, үйлчилгээ үзүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдах ажилтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцох;

3.1.7.тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хуулийн хугацаанд олгох;

3.1.8.ил тод, хэмнэлттэй, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, энэ хүрээнд эдийн засгийн өсөлтийг дэмжиж, төсвийн сахилга батыг чангатган, төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулах.

Дөрөв.Гэрээг дүгнэх

4.1. Гэрээний биелэлтийн хагас жилийн тайланг 2024 оны 06 дугаар сарын 25, бүтэн жилийн тайланг 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

4.2.Гэрээний хавсралт болох “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний жилийн эцсийн биелэлтийг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлнэ.

Тав.Гэрээний хариуцлага

5.1.Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлээгүй, гэрээний хавсралт болох “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг дутуу гүйцэтгэсэн, өмнөх үр дүнг бууруулсан, хүрэх түвшинд хүргээгүй, сахилга, хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлгээлгэнэ.

Зургаа.Бусад зүйл

6.1.Талууд гэрээнд тусгагдсан үүргээ харилцан биелүүлнэ.

6.2.Гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд талууд харилцан бичгээр санал тавьж, зөвшилцөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6.3.Гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд гэрээг баталгаажуулан гарын үсэг зурж, хоёр хувь үйлдэх бөгөөд энэхүү өөрчлөлт нь энэ гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.4.Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус тус 1 хувийг хадгална.

Гэрээ байгуулсан:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА




С.БАТЖАРГАЛ

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ




Х. Нямбаатар 2024.01.05 Х.НЯМБААТАР

Төлөвлөгөө баталсан:

Төсвийн Шууд захирагч

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



С.БАТЖАРГАЛ

2024.01.05

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа I-IV улирал/	Хариуцах нэгж
НЭГ. Стратегийн төлөвлөгөөний зорилго 1. Эдийн засгийн зорилтот түвшинг хангах үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулна. НСТ-3.2.							
1	1.1 Цэвэрлэх байгууламж барих хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулах.	-	БХБЯ, НЗДТГ-т хүсэлт гаргах ажлын гүйцэтгэл, хувь	Зураг төсөв хийгдсэн.	50	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
2	1.2 Дулааны станцын төсвийг шинэчилж батлуулах.	-	ЭХЯ, НЗДТГ-т хүсэлт гаргах ажлын гүйцэтгэл, хувь	Зураг төсөв хийгдсэн.	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
3	1.3 Паркийн дэд бүтцийн барилга байгууламжуудын гадна цахилгаан хангамжийн зураг төсвийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж зураг төсийг хийлгэх	-	БХБЯ, НЗДТГ-т хүсэлт гаргах	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
ХОЁР. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулна. НХТЖҮЧ-4.3.3, НЗДҮАХ-3.2.2.1, НЗДҮАХ-6.2.1.6							
4	2.1 Үндсэн цахилгаан хангамжийн ажлыг үргэлжлүүлэн, гүйцэтгэлийн ажилд хяналт тавин ажиллах	7,500.0	Ажлын гүйцэтгэл, хувь	Барилга угсралтын ажил 87 хувь хийгдсэн.	100	I-II улирал	НБМҮТП ОНӨТҮГ
5	2.2 “Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн ТЭЗҮ, ХЕТ боловсруулах, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг эхлүүлэх	Төр хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгүүлэх	Ажлын гүйцэтгэл, хувь	60 га газрын гэрээ, гэрчилгээ гарсан.	40	I-IV улирал	ХБХГ “НБМҮТП” ОНӨТҮГ
ГУРАВ. Зорилт 3. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт. – Парктай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн акт, дүрмээр тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлэх, бодлого боловсруулах, зохицуулах, зохион байгуулах, боловсон хүчнийг бүрдүүлэх, чадавхжуулах, нийгмийн баталгааг хангаж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллана.							
6	3.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах	481.85 Нийслэлийн төсөв	Ажлын гүйцэтгэл, хувь	НАГ-т 2016-2018 оны санхүүгийн тайланг шалгуулж зөрчилгүй санал дүгнэлт авсан.	100	II-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
7	3.2 Улс нийслэлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт санал боловсруулж, тусгуулах	-	Бодлогын баримт бичигт туссан үйл ажиллагаа, тоо	5	3	I-IV	НБМҮТП ОНӨТҮГ
8	3.3 Оффисын барилгын засварын ажил хийх	18.0 Нийслэлийн төсөв	Ажлын гүйцэтгэл, хувь	Барилгын засварын ажил	100	II улирал	НБМҮТП ОНӨТҮГ
9	3.4 Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2024 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэх	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
10	3.5 Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хэтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
11	3.6 Паркийн хуулийн этгээдийн хэлбэрийг хуульд нийцүүлэн өөрчилж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-II улирал	НБМҮТП ОНӨТҮГ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
12	3.7 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
13	3.8 Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд эзэмшил газар дээр орон сууц барих судалгааны ажлыг эхлүүлж бичиг баримтын бүрдлийг хангах.	-	Хэрэгжилт, хувь	10	30	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
14	3.9 Налайх дүүргийн иргэдийг ажлын байраар хангах	-	Хангагдсан иргэд	100	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
15	3.10 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх	-	Хэрэгжилт, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
16	3.11 Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийг биелэлтийг тайлагнах	-	Хэрэгжилт, хувь	100	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
17	3.12 Дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд аж ахуйн нэгжүүдэд паркийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, танилцуулга материал, товхимлуудыг түгээж, хамтарсан уулзалт зөвлөгөөн зохион байгуулах.	-	Монгол хэл дээр 200 ширхэг танилцуулга материал хэвлүүлж тараах, 3 уулзалт зохион байгуулах. Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
18	3.13 Гадаадын хөрөнгө оруулагчид /Солонгос, Хятад/, иргэд аж ахуйн нэгжүүдэд паркийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хөрөнгө оруулалт татах боломжуудын талаар танилцуулж хамтарсан уулзалт зөвлөгөөн зохион байгуулах.	-	Англи, Солонгос, Хятад хэл дээр 200 ширхэг танилцуулга материал хэвлүүлж тараах, 3 уулзалт зохион байгуулах. Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
19	3.14 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.	-	62 төрлийн мэдээлэл оруулах. Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
20	3.15 “Тэрбум-мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих, өмнө нь тарьсан модны арчилгаа, усалгаа хийх.	-	Шинээр тарьсан мод, тоо	Хайлаас 300, 10 улиас, 50 монос тарьсан.	200	II, III улирал	НБМҮТП ОНӨТҮГ
21	3.16 Хот төлөвлөлт, хот байгуулалтын стандартын барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS 0301B-г таниулах ажлыг зохион байгуулах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
22	3.17 Нийгмийн дэд бүтцийн стандартын төрийн байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага UCS 1104B-г хэрэгжүүлэн ажиллах.	-	Стандартын дагуу гадна орчныг тохижуулах ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
23	3.18 Хог хаягдлын менежментийн стандартын аюултай хог хаягдлын менежмент UCS 1703А, барилгын хог хаягдлын менежмент UCS 1706А, хог хаягдлын устгалын стандарт, устгалын удирдамж UCS 1705А баримт бичгүүдийг таниулах ажлыг зохион байгуулах.	-	Паркт байршиж буй аж ахуйн нэгжүүдэд таниулах, мөрдлөг болгон ажиллах ажлыг зохион байгуулах ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
ДӨРӨВ. Зорилт 4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт. Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах							
24	4.1 Паркийн нутаг дэвсгэрт шинээр үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах, бүтээн байгуулалтыг эхлүүлэх.	-	Шинээр гэрээ байгуулан ажиллах ААН, тоо	2	15	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
25	4.2 Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах	-	Ажлын гүйцэтгэл, хувь	2017 онд 5 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл авсан.	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
26	4.3 Паркийн 130 га талбайн ХЕТ-г батлуулан хүлээн авах, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын тооцоолол гаргах, хөрөнгө татах ажлыг эхлүүлэх.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	2023 онд “Өрх” ХХК гүйцэтгэсэн.	50	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
27	4.4 Паркийн 250 га талбайд техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх хөрөнгө оруулалтыг татах ажлыг эхлүүлэх.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	2016 онд “Мецачү” ХХК 120 га талбайд хийсэн.	100	II-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
28	4.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон MNS ISO 45001:2018 стандартыг мөрдөх, төлөвлөгөө гарган ажиллах	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
ТАВ. Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт. Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэнэ.							
29	5.1 Гүний худгийг улсын бүртгэлд бүртгүүлэх паспортжуулах гэмтэл гарсан худгийг засварлан хэвийн горимд оруулах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	II-III улирал	НБМҮТП ОНӨТҮГ
30	5.2 Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
31	5.3 Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлага үүсэх эрсдэлийг бууруулах.		Байгууллагын сайт, цахим хуудсанд үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол байршуулах. Хэрэгжилт, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
32	5.4 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
33	5.5 Албан хэрэг хөтлөлтийн Эдок системд албан хаагчид зөрчил үүсгэхгүй, албан бичгийн норм стандартыг мөрдөх, хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
34	5.6 Албан хаагчдад үүссэн цаасан болон тусгай төрлийн баримтыг хуваарийн дагуу хүлээн авч байгууллагын архивд бүрдүүлэлт хийх.	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
35	5.7 2023 оны үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлалын баримт бичгээ цахим хэлбэрт шилжүүлэн байгууллагын архивын "Archive eDoc" системд хөрвүүлж, нягтлан шалгах ажлыг хийж гүйцэтгэн төрийн архивт цахим нөхөн бүрдүүлэлт хийн захирамжлалын баримтыг цахимжуулсан байх.	-	Ажлын гүйцэтгэл хувь	-	100	I улирал	НБМҮТП ОНӨТҮГ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
36	5.8 Архивын гэрчилгээ авах ажлыг зохион байгуулах.	-	Ажлын гүйцэтгэл хувь	-	100	IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
37	5.9 Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээрээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухай бүрд нь гаргаж хүргүүлэх.	-	НБМҮТП-ийн үйл ажиллагаатай холбоотой үүрэг даалгаврын гүйцэтгэлийг хянаж, биелэлтүүдийг гаргах Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
Зургаа. Зорилт 6. Хотын хөгжлийн индексийг хэрэгжүүлэх зорилт. Тогтвортой, хүртээмжтэй байх							
38	6.10 Хөдөлмөр эрхлэлтийн төвшин нэмэгдүүлэх	-	Хэрэгжилт хувь	2	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮ
39	6.11 Инженерийн дэд бүтцийн хүртээмжийг үйлдвэрүүдэд тэгш хүргэх	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮ
Долоо. Зорилт 7. Тохижилт-Бүтээн Байгуулалтын жилийн хүрэнд хэрэгжүүлэх зорилт.							
40	7.1 Налайх паркийн нэгж болох аж ахуй нэгжүүд хариуцсан орчиндоо ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	-	Хэрэгжилт хувь	-	100	II-IV	НБМҮТП ОНӨТҮ
41	7.2 Байгууллагын 30м2 газрыг ногоон байгууламж болгох	-	Хэрэгжилт хувь	-	100	II-IV	НБМҮТП ОНӨТҮ
42	7.3 Нийслэлийн үйлдвэрлэл, технологийн паркуудын 10-н жилийн ойн хүрээнд орчны тохижилт бүтээн байгуулалт хийх олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	-	Хэрэгжилт хувь	-	100	II-IV	НБМҮТП ОНӨТҮ